

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2009 оны 9 дүгээр
сарын 10-ны өдөр

Дугаар 193

Улаанбаатар хот

“МИК” бондыг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 3.1.1, 3.1.7, 3.1.12 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Монголын ипотекийн корпораци” ХХК-ийн нийтэд санал болгон гаргах 2,5 жилийн хугацаатай жилийн 14 хувийн хүүтэй, 3,5 жилийн хугацаатай жилийн 14,3 хувийн хүүтэй, 5 жилийн хугацаатай жилийн 14,5 хувийн хүүтэй нэг бүр нь 1 000 000 /нэг сая/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 25 000 /хорин таван мянга/ ширхэг орон сууцны барьцаагаар баталгаажсан “МИК” бондыг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/, төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д тус тус зөвшөөрсүгэй.
2. Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан “Монголын ипотекийн корпораци” ХХК-ийн 25 000 ширхэг бондноос эхний ээлжинд 10 000 /арван мянга/ ширхэг бондыг худалдахыг зөвшөөрч, үлдсэн 15 000 /арван таван мянга/ ширхэг бондыг худалдахдаа Хороонд мэдэгдэж зохих зөвшөөрөл авсны үндсэн дээр худалдахыг “Монголын ипотекийн корпораци” ХХК /Ц.Энхбаяр/-д үүрэг болгосугай.
3. Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан бондын хүү, хугацааг ипотекийн зээлийн хүү, хугацаатай уялдуулан тогтоож, энэ тухай Хороонд мэдэгдэхийг “Монголын ипотекийн корпораци” ХХК /Ц.Энхбаяр/-д үүрэг болгосугай.
4. Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан бондоор худалдан авах зээлийн багцад байгаа хөрөнгийн жагсаалтыг, үнэт цаас гаргагчын Төлөөлөн удирдах зөвлөлийн 2008 оны 08/Т/3-1 тогтоолоор баталсан “Ипотекийн зээлийн хөрөнгийг худалдан авах үйл ажиллагааны журам”-д заасан мэдээллийг бүрэн тусгаж, “Энэхүү жагсаалтад дурдсан бүх мэдээлэл нь үнэн зөв бөгөөд хэрэв худал мэдээлэл өгсний улмаас хожим бусдад хохирол учирвал Монголын ипотекийн корпораци ХХК бүрэн хариуцна гэдгийг түүний нэрийн өмнөөс Санхүүгийн зохицуулах хороонд нотолж байна” гэж бичиж гарын үсэг зурж баталгаажуулан Хороонд ирүүлж байхыг “Монголын ипотекийн корпораци” ХХК /Ц.Энхбаяр/-д үүрэг болгосугай.
5. Хорооноос явуулсан мэдэгдлийг үндэслэн үнэт цаасны хадгаламж дахь үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг баталгаажуулж байхыг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д үүрэг болгосугай.
6. Биржийн бус арилжаагаар хийгдэж буй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны өмчлөх эрхийн болон түүний шилжилтийн бүртгэлийн үйлчилгээний хөлсийг тухайн хэлцлийн үнийн дүнгийн 0,01 хувиас хэтрүүлэхгүйгээр тогтоох асуудлыг компанийн төлөөлөн удирдах зөвлөлд тавьж шийдвэрлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д даалгасугай.

7. Арилжааны тайланг хуульд заасан хугацаанд Хороонд ирүүлж, хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлж ажиллахыг “Монголын ипотекийн корпораци” ХХК /Ц.Энхбаяр/-д тус тус үүрэг болгосугай.

8. Бондын борлуулалт, үндсэн болон хүүгийн төлбөр төлөлтөд холбогдох журмын дагуу хяналт тавьж ажиллахыг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д тус тус даалгасугай.

9. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/, олон нийгэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-г тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН